



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/110/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70523020

Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.Төрийн аудитын санал, дүгнэлт


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

АЙМГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.ДАВААДОРЖ ТАНАА

2021.02.10 № 1-6/45
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Шүүхийн тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,769,390.00	12,817,555.70
35	БАРАА МАТЕРИАЛ	4,769,390.00	12,817,555.70
35100	Түүхий эд материал	0.00	0.00
35400	Хангамжийн материал	4,769,390.00	12,817,555.70
35410	Бичиг хэргийн материал	0.00	2,091,000.00
35420	Аж ахуйн материал	4,232,550.00	4,075,901.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	6,650,654.70
35470	Бусад хангамжийн материал	536,840.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	955,561,011.62	1,015,507,396.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	955,561,011.62	1,015,507,396.79
39200	Биет хөрөнгө	905,116,011.62	963,334,271.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	859,623,545.78	852,298,945.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,512,544.96	-41,650,433.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	93,350,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-93,350,000.00	-972,222.22
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	186,273,436.01	105,763,241.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-166,367,981.85	-36,170,955.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	101,008,859.60	105,427,675.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,286,687.92	-57,584,078.76
39209	Зам, гүүрийн байгууламж	1,105,950.00	1,105,950.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-184,325.04	-368,650.08
39217	Ном	455,760.00	484,800.00
39300	Биет бус хөрөнгө	50,445,000.00	52,173,125.01
39301	Програм хангамж	825,000.00	1,825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	-96,874.99
39303	Бусад биет бус хөрөнгө	50,445,000.00	50,445,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	960,330,401.62	1,028,324,952.49
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	960,330,401.62	1,028,324,952.49
51	Засгийн газрын хувь оролцоо	960,330,401.62	1,028,324,952.49
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	396,557,624.46	396,557,624.46
51200	Хуримтлагдсан үр дүн	1,174,504.24	69,169,055.11
51210	Өмнөх үеийн үр дүн	118,435,321.09	1,174,504.24
51220	Тайлант үеийн үр дүн	-117,260,816.85	67,994,550.87
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	562,598,272.92	562,598,272.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	960,330,401.62	1,028,324,952.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,018,192,010.00	1,210,283,380.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,614,210.00	99,654,980.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,614,210.00	99,654,980.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,592,910.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,592,910.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	20,529,640.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	969,940.00
120009	Бусад орлого	21,300.00	78,155,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,014,577,800.00	1,110,628,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,014,577,800.00	1,105,628,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,014,577,800.00	1,105,628,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,000,000.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	5,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,135,452,826.85	1,142,288,829.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,135,452,826.85	1,142,288,829.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,133,256,441.38	1,107,194,851.13
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	797,689,700.00	844,472,200.00
210101	Цалин	609,190,500.00	653,118,500.00
210102	Нэмэгдэл цалин	149,728,300.00	150,230,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,662,000.00	25,546,900.00
210104	Урамшуулал	13,108,900.00	15,576,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,711,200.00	105,702,591.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	67,283,600.00	81,145,600.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	8,106,900.00	8,364,000.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6,485,500.00	6,691,200.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,621,400.00	1,672,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	16,213,800.00	7,828,991.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,036,214.53	26,232,200.00
210301	Гэрэл цахилгааны зардал	3,142,197.53	3,870,425.00
210302	Түлш, халаалтын зардал	21,182,817.00	20,575,900.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,711,200.00	1,785,875.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,081,950.00	45,569,485.30
210401	Бичиг хэргийн материал	14,902,700.00	13,781,640.00
210402	Тээвэр, шатахууны зардал	24,948,800.00	11,357,756.30
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	8,446,700.00	8,690,120.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	264,000.00	1,164,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	3,519,750.00	10,575,969.00
2105	Нормативт зардал	800,000.00	1,098,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	1,098,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	17,466,500.00
210601	Багаж хэрэгсэл	5,000,000.00	2,466,500.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	15,000,000.00
2107	Томилот, зочны зардал	13,783,900.00	8,906,100.00
210702	Дотоод томилотын зардал	13,783,900.00	8,906,100.00

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,798,200.00	5,596,020.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,214,700.00	3,683,900.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	1,555,800.00	1,555,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207,200.00	84,320.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	32,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	247,500.00	-
210807	Газрын төлбөр	300,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,355,276.85	52,151,354.83
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,355,276.85	52,151,354.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,196,385.47	35,093,978.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	20,026,404.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16,026,404.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,000,000.00	4,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	196,385.47	15,067,574.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	196,385.47	15,067,574.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(117,260,816.85)	67,994,550.87
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(117,260,816.85)	67,994,550.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,014,577,800.00	1,110,628,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,014,577,800.00	1,110,628,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,014,577,800.00	1,105,628,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,014,577,800.00	1,105,628,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	5,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,012,577,800.00	1,097,215,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,012,577,800.00	1,097,215,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,010,381,414.53	1,062,121,722.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	797,689,700.00	844,472,200.00
210101	Үндсэн цалин	609,190,500.00	653,118,500.00
210102	Нэмэгдэл	149,728,300.00	150,230,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,662,000.00	25,546,900.00
210104	Урамшуулал	13,108,900.00	15,576,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,711,200.00	105,702,591.00
210201	Тэтгэврийн даатгал	67,283,600.00	81,145,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,106,900.00	8,364,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,485,500.00	6,691,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,702,200.00	1,672,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,133,000.00	7,828,991.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,036,214.53	26,232,200.00

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	3,142,197.53	3,945,100.00
210302	Түлш, халаалт	21,182,817.00	20,575,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,711,200.00	1,711,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,562,200.00	51,825,311.00
210401	Бичиг хэрэг	14,902,700.00	14,902,700.00
210402	Тээвэр, шатахуун	24,948,800.00	18,008,411.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,446,700.00	9,246,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	264,000.00	1,164,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	8,503,500.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	18,587,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	3,587,300.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	15,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,783,900.00	8,906,100.00
210702	Дотоод албан томилолт	13,783,900.00	8,906,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,798,200.00	5,596,020.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,214,700.00	3,683,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,555,800.00	1,555,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207,200.00	84,320.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	32,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	0.00
210807	Газрын төлбөр	300,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,196,385.47	35,093,978.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	20,026,404.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	16,026,404.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	4,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	196,385.47	15,067,574.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	196,385.47	15,067,574.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,000,000.00	13,412,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,000,000.00	13,412,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,000,000.00	13,412,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,000,000.00	13,412,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,000,000.00	13,412,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,000,000.00	-13,412,700.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,557,624.46	562,598,272.92	118,435,321.09	1,077,591,218.47
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	396,557,624.46	562,598,272.92	118,435,321.09	1,077,591,218.47
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(117,260,816.85)	(117,260,816.85)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,557,624.46	562,598,272.92	1,174,504.24	960,330,401.62
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,557,624.46	562,598,272.92	1,174,504.24	960,330,401.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	396,557,624.46	562,598,272.92	1,174,504.24	960,330,401.62
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	67,994,550.87	67,994,550.87
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	396,557,624.46	562,598,272.92	69,169,055.11	1,028,324,952.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,105,628,400.00	1,090,560,826.00	15,067,574.00	99%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,105,628,400.00	1,090,560,826.00	15,067,574.00	99%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,085,588,400.00	1,070,534,422.00	15,053,978.00	99%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	844,472,200.00	844,472,200.00	-	100%
210101	Үндсэн цалин	653,118,500.00	653,118,500.00	-	100%
210102	Нэмэгдэл	150,230,400.00	150,230,400.00	-	100%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,546,900.00	25,546,900.00	-	100%
210104	Урамшуулал	15,576,400.00	15,576,400.00	-	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,601,600.00	105,702,591.00	8,899,009.00	92%
210201	Тэтгэврийн даатгал	81,145,600.00	81,145,600.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	8,364,000.00	8,364,000.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,691,200.00	6,691,200.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,672,800.00	1,672,800.00	-	100%

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	16,728,000.00	7,828,991.00	8,899,009.00	47%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,232,200.00	26,232,200.00	-	100%
210301	Гэрэл, цахилгаан	3,945,100.00	3,945,100.00	-	100%
210302	Түлш, халаалт	20,575,900.00	20,575,900.00	-	100%
210303	Цэвэр, бохир ус	1,711,200.00	1,711,200.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	57,765,700.00	51,825,311.00	5,940,389.00	90%
210401	Бичиг хэрэг	14,902,700.00	14,902,700.00	-	100%
210402	Тээвэр, шатахуун	23,948,800.00	18,008,411.00	5,940,389.00	75%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,246,700.00	9,246,700.00	-	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,164,000.00	1,164,000.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,503,500.00	8,503,500.00	-	100%
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00	-	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	-	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,000,000.00	27,000,000.00	-	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,000,000.00	17,000,000.00	-	100%
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100%
2107	Томилолт, зочны зардал	8,996,800.00	8,906,100.00	90,700.00	99%
210702	Дотоод албан томилолт	8,996,800.00	8,906,100.00	90,700.00	99%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,719,900.00	5,596,020.00	123,880.00	98%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,683,900.00	3,683,900.00	-	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	1,555,800.00	1,555,800.00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207,200.00	84,320.00	122,880.00	41%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	32,000.00	1,000.00	97%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20040000.00	20026404.00	13,596.00	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,040,000.00	20,026,404.00	13,596.00	100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,040,000.00	16,026,404.00	13,596.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	4,000,000.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,105,628,400.00	1,105,628,400.00	-	100%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,105,628,400.00	1,105,628,400.00	-	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,105,628,400.00	1,105,628,400.00	-	100%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	05.00	05.00	-	100%
610001	Төсвийн байгууллага	05.00	05.00	-	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39.00	39.00	-	100%
620001	Удирдах ажилтан	05.00	05.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	-	100%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39.00	39.00	-	100%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	16.00	16.00	-	100%
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	12.00	12.00	-	100%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	-	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		5,000,000.00	-5,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,000,000.00	-5,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,000,000.00	-5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,000,000.00	-5,000,000.00
210604	Урсгал засвар		5,000,000.00	-5,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		5000000.00	-5,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		5,000,000.00	-5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00	-5,000,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Даваадорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 27-ноос 2021 оны 01 дүгээр сарын 29-ний хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 21-ний өдрийн 21 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Шүүхийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох
- Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллыг хамгаалах
- Хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх
- Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын НБББББ-т өөрчлөлт орсон гэж байгаа боловч 2020 оны жилийн эцсийн байдлаар хэвлэгдэж гараагүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймгийн Шүүхийн тамгын газар нь 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын алба 2020 оны 11 сард санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 2,118.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж холбогдох зөвлөмжийг өгсөн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд сайн гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3-р улирлын тайлангийн нийт хөрөнгийн 9,735,663.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,735.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ. Гүйцэтгэлийн үе шатны материаллаг түвшнийг нийт зардлын 1,142,288.8 мянган төгрөгийн 1 хувиар 11,422.8 мянган төгрөгөөр тогтоов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67,994.5 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	4,769.4	12,817.6	8,048.2
Үндсэн хөрөнгө	955,561.0	1,015,507.4	59,946.4
Нийт хөрөнгө	960,330.4	1,028,324.9	67,994.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	960,330.4	1,028,325.0	67,994.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	960,330.4	1,028,325.0	67,994.5

Бараа материалын дансны үлдэгдэл 12,817.6 мянган төгрөг болж 8,048.2 мянган төгрөгөөр өссөн цар тахалтай холбоотойгоор тээвэр шатахууны зардалд үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,015,507.4 мянган төгрөг болж 59,946.4 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээ хийж, ашиглах хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг үнэлж бүртгэснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 13,412.7 мянган төгрөгийн худалдан авалт хийснээр мөн нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 20,529.6 мянган төгрөг, акталсан 1,767.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Аймгийн Шүүхийн тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 192,091.4 мянган төгрөгөөр буюу 18.9 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 6,836.0 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,354,529.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,354,529.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 248,900.9 мянган төгрөгөөр бууруулж 1,105,628.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,105,628.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,105,628.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,105,628.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,110,628.4 мянган төгрөгийг зарцуулж 15,067.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган 1,110,628.4 төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 8,899.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал буюу тээвэр шатахууны зардлыг 5,940.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 90.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 15,067.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Энэ нь 2020 оны 1-3 дугаар улирлуудад орон тоо дутуу ажилласнаас нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 8,899.0 мянган төгрөгөөр, цар тахал, хорио цээртэй холбоотойгоор тээвэр шатахууны зардал 5,940.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 90.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосноор нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шат хийхэд 2,744.9 мянга, дотор засалд 2,255.3 мянган төгрөг буюу нийт 5000.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 43 мэдээллээс хугацаандаа оруулсан 42 мэдээлэл, хугацаа хоцроосон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэсэн 1 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,895.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх тухай 1 зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилт 10 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,895.4	1	1,895.4			
Албан шаардлага							
Зөвлөмж	1		1				
Нийт дүн	2	1,895.4	2	1,895.4			

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 77,993.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 69,998.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,338.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Мөн завсрын аудитаар 6,414.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд ерөнхий журналыг шалгахад 1,120.8 мянган төгрөгийн үнэ бүхий цаас устгагч, нуруулдагч, гэрэлт хаяг, баримт үдэгч, шат зэрэг хөрөнгө худалдан авсныг бараа материалын дансанд бүртгээд зарлагдсаныг дахин бүртгэлд тусгаж залруулав.
- Мөнгөн гүйлгээний журналын ажил гүйлгээг шинжлэхэд нийт 68,800.4 мянган төгрөгийн 108 ширхэг гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэж тайлагнасныг залруулав.
- Гэрэл цахилгааны зардлаас 74.7 мянган төгрөгийг цэвэр, бохир усны төлбөрт шилжүүлснийг тухайн зардлын бодит гүйцэтгэлээр тайлагнаагүйг залруулав.

Аудитаар алдаа зөрчлийг давтан гаргах тухай 2,338.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд шуудан холбооны зардлаас 1,984.0 мянган төгрөгөөр программ сунгалтын төлбөр, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 354.0 мянган төгрөгөөр нормын хувцас худалдан авах зардлаас тус тус шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоох.

2. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 ширхэг 6.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна. /Завсрын аудитаар менежментийн захидал хүргүүлсэн/
3. Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

Аудитын зөвлөмж

Завсрын аудитаар илэрсэн 6,414.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусган хүргүүлсэн байна.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудалд байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021/01/29	Аудитын нэр: Аймгийн Шүүхийн тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2021/110/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Аймгийн Шүүхийн тамгын газар	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд шуудан холбооны зардлаас 1,984.0 мянган төгрөгөөр программ сунгалтын төлбөр, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 354.0 мянган төгрөгөөр нормын хувцас худалдан авах зардлаас тус тус шилжүүлсэн байна.	2,338.0	Албан шаардлага тогтоох	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Нягтлан бодогч	Т.Даваадорж А.Одонтуяа
2	Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг шүүж үзэхэд байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэр төрлийн 3 ширхэг 76.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	6,414.5	Зөвлөмж хүргүүлэх /завсрын аудит/	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Нягтлан бодогч	Т.Даваадорж А.Одонтуяа
ДҮН		8,725.5			